

Амьдрал хотод биш хотонд байна

Намрын налгар өдрүүд хэвийн үргэлжилж говь нутаг анир гүм хийгээд амар амгалан. Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд өвс ногоо элбэг мал сүрэг тарга тэвээр сайтай сайхан намар болжээ. Энд түм түжигнээгүй бум бужигнаагүй атлаа хэн ч юунд ч үл сатааран толгой өндийх завгүй ажиллах аж. Хөдөө нутгийн эд эс нь болсон цаг наргүй ажил хийгээд байгалийн сайхныг нь мэдрэхээр иргэд нийслэл хотоос хөдөөг зорих болжээ. Тухайлбал; Үндэсний статистикийн хорооноос мэдээлснээр 2015-2020 оны хооронд нийт 43478 иргэн Улаанбаатар хотоос хөдөө орон нутаг руу шилжсэн байна. Хотод мөнгө төлөөд ч авч чадахгүй үнэт зүйлс болох цаг хугацаа, аз жаргал, эрүүл мэнд, амар тайван амьдрал хөдөө нутагт үнэгүй байна.

Dragon-аас Дэлгэрцогт сум руу явах унаанд суугаад тасралтгүй 2 цаг гаруй давхисны эцэст өдрийн бага үдэд зорьсон газартаа ирлээ. Зориглосон газартаа ирсэн болохоор жолооч ахад аян замын ерөөл өргөөд аялалаа цааш үргэлжлүүлэв. Ийнхүү хэсэг явсаар сумын жижиг гуанзны дэргэд очиход "Приус 41" маркын машины хажууд нэгэн хүн зогсох ба тухайн хүн "Сайн явж ирэв үү" гэж асуугаад машинд суухыг санал болгов. Түүнийг тодорхойлбол дунд зэргийн нуруу, аргил бадируун бие, нар салхинд гандсан шаргал арьс, онигор нүд, шонтгор хамар, нимгэн уруул зэрэг нь говь нутгийн хүн гэдгийг нь илтгэх аж. Тэрбээр намайг тосохоор сумын төв дээр хүлээж байсан нь энэ ажээ. Эднийх сумын төвөөс 40 гаруй км зайд "Хажуу худаг" гэх газар байх ба бид хоёул мэнд усаа мэдэлцээд намаржаа хүрэх зам зуураа хөдөөгийн амьдралын шалдар булдир хийгээд сонин сайхан зүйлсийн тухай ярилцаж түүнтэй малчин болсон талаар нь ийн хөөрөлдөн явсан юм.

Тарган сайхан намаржиж байна уу? Мал сүрэг тарга сайн авав уу?

Сайхан намаржиж байна. Манай нутагт өвс ногоо халиурсан жигтэйхэн сайхан намар болж байна. Хур бороо ихтэй өвс ногоо элбэг зуншлага сайн байсан болохоор, мал сүрэг маань тарга тэвээрэг сайтай сайхан байна. Малчин хүн бүрийн жаргал энэ юм даа мал сүрэг сайн байгаа болохоор даагаад сэтгэл санаа хүртэл сайхан болох юм аа. (инээв)

Та хэзээнээс мал маллах болов?

Аав ээж минь малчин хүмүүс байсан болохоор би хүүхэд байхаасаа мал маллаж малын хөлийн тоосонд дарагдаж өссөн дөө. Тэднийхээ зааж сургасаны ачаар өөрийгөө өдий зэрэгтэй яваа гэж боддог. Сургуулиа төгсөөд 2008 онд Улаанбаатар хотод оюутан болоод очиж байсан. Тухайн цагт ШУТИС КТМС гэж байхад Компьютерийн техник хангамжийн мэргэжилээр суралцаад 2012 онд төгсөж байсан юм. Оюутан байх хугацаа хотод бас бус амьдарч байсан үеийг эс тооцвол тасралтгүй 20 гаруй жил мал маллаж байна даа.

Улаанбаатар хотод оюутан болоод очиж байсан гэж ярилаа энэ талаар та дэлгэрэнгүй ярьж болох уу?

Бололгүй яахав. Хүн болгон тухайн үед хот хүрээг зорьж байсан. Би ч ялгаагүй тэдний адилаар хотод очиж үзэх хүсэл зорилгодоо хөтлөгдөөд оюутан нэрийн доор анх очиж байсан. Юм гэдэг харагддаг шигээ байдаггүй гэдгийг тэр үед маш сайн ойлгосон. Хүүхэд байсан болоод ч тэрүү нэг их юм бодолгүй шууд л явсан, дотроо бодохдоо хотод очоод үзчих юм бол сайхан амьдарна, бүх зүйлийг шинээр эхэлнэ гээд явсан даа. Одоо бодоход энэ их зориг миний хаанаас гарсан юм бүү мэд, ямар ч төлөвлөгөөгүй сохор азандаа найдаад явсан гэхээр зоригтой байгаа биздээ. (Инээв)

Гэхдээ би үүнд харамсаж халаглаад байдаггүй харин ч надад үнэтэй сургамж болсон гэж бодож явдаг. Одоо бол зүгээр болоод өнгөрсөн юм бүхэнд баярладаг. Ингэж явсан болоод би өдий зэрэгтэй яваа биз. Хүн ер нь байгаа жаргалдаа хэт ташуураад ирхээрээ хазгай муруй гишгэчих гээд байдаг талтай, тэр бүрт юун дээр гишгэсэнээ эргээд хардаг байх нь чухал.

Их хотын амьдрал танд хэцүү санагдаж дээ?

Энгийнээр тайлбарлавал хотод амьдрах боломж байхгүй гэдгийг ойлгосон гэж хэлмээр юм уу даа.

Яагаад хөдөөг зорих болов?

Их хотын уур уцаартай амьдрал таагүй санагдаад л тэр.

Хот хөдөөгийн ялгаа нь?

Хүн бүрт л харилцан адилгүй санагдах байлгүй дээ, хэсэг нэгэн хот гэж хэлэх бол зарим нь хөдөөг илүүд үзнэ. Мэдээж энэ хоёр газарыг өөр хооронд нь ялгаатай санагдуулах зүйл ганц нэг жишээгээр тогтохгүй маш олон байгаа. Лав миний дүгнэж байгаагаар хөдөө амьдрахад илүү таатай. Жишээ нь Нийслэлийг бодвол хөдөө

санхүүгийн хувьд хамаагүй хэмнэлттэй бас гэмт хэргийн гаралт бага, цэвэр агаар сайтай, дуу чимээ бага үүнийгээ дагаад сэтгэл санаа ч тайван стресс багатай, сүү цагаан идээнд ойр, хамгийн органик юм бүхнийг иднэ. Чанартай, баталгаатай, найдвартай юм иднэ гэдэг сайхан биз. Хотод сайн чанарын эрүүл хүнс олно гэдэг амаргүй, би өөрөө тэнд амьдарч үзсэн хүний хувьд сайн мэдэж байна. Хаанаас ирсэн мах, хаана тарьсан ногоо, гээд бодож бухимдах асуудал их. Манайх мал маллахын хажуугаар өөрсдөө ногоогоо тарьдаг. Өөрийн юм өөгүй гэгчээр цэвэрхэн хөрсөнд элдэв химийн бордоогүй тарьж ургуулсан ногоо цагаагаа хоол хүнсэндээ хэрэглээд болоод л байдаг. Тийм ч болохоор энэ тал дээр нэг их санаагаа зовоож сэтгэлээ чилээдэггүй. Мөн нэг жишээг нэмээд хэлэхэд монгол мал өөрт хэрэгтэй гэсэн зүйлээ голж шилж иддэг амьтан. Гадныханыг хараад байхад мал ахуйдаа юу хамаагүй элдэв зүйлийн тэжээл өгч харагддаг. Харин монголд тийм биш, морь мал нь бэлчээр дээрээсээ байгаль дээрх эмийн ургамал, шим тэжээлтэй өвс ногоогоо олоод идчихнэ. Үүгээрээ монгол мал байгаль дээрх зэрлэг амьтнаас нэг их ялгагдаад байхгүй. Ингээд бодохоор монголоос өөр хаана ч ийм органик мах байхгүй гэж бодогдож байгаа биздээ. Яг ийм органик хүнсийг гадаадад тансаг хэрэглээ хэмээн өндөр үнээр авдаг гэж сонсож байсан. Махны асуудал хаа сайгүй яригдаж байх шиг байна. Аргагүй биздээ хөөрхий юу нь мэдэгдэхгүй баталгаагүй юм хэрэглээд байгаа хүмүүс энэ талаар ярьж хэлэлцэхгүй гээд яахав. Энэ асуудал хөдөө бол харьцангуй бага яригддаг. Хөдөөнийхөн бид баталгаатай органик хүнсээ өөрсдөө бэлдэж хэрэглээд сайхан амьдарч болоод байгаагийн тод жишээ энэ.

Та сая давуу талыг нь ярилаа тэгвэл сул тал нь юу вэ?

Давуу талыг нь ярьж хэлбэл тоочоод барахгүй биз. (инээв) Нэг үеэ бодвол юм хөгжөөд сайхан болж гэхдээ сайхан боллоо гээд асуудал дагаад арилах бишдээ. Хичнээн хөгжиж байгаа ч энд мэдээллээс хоцрох гээд байдаг талтай. Хотод байдаг элбэг зүйлс энд барагтай л олдохгүй. Бие хаа өвдлөө гэхэд нарийн шинжилгээ эмчилгээг нь энд авахад ихээхэн хүндрэлтэй, нэмээд хэлэхэд боловсролын асуудал хамгийн хэцүү.

Ийн яриа өрнүүлж, хонхор хүнхэр замаар дэрс сүлжин давхисаар намаржаанд нь ирэв. Намаржаа хүрэх зам 40 өөдхөн км боловч бартаа ихтэй учир баргийн машин явахааргүй аж. Элс шороорхуу хөдөө талын дэрс дунд Цэмцийтэл барьсан хоёр гэр байх ба зүүн талынх нь Н.Мөнхбаяр ахынх ажээ. Машинаас буухад сэнгэнэсэн цэвэр агаар цээж дүүргээд, малын өтөг бууц хамар цоргион сэтгэл санааг тайвшруулах шиг. Яг энэ үеэр ах хүү машины хойд талын суудал дээрээс сумын төвөөс авсан

жаал жуул юмыг даавуун торонд нямбайлан хийж дуусаад гэрт орохыг санал болгов.

Гэрт орлоо, Сайн явж ирэв үү, хэмээн хоол цайгаар угтах энэ хүү Н.Мөнхбаяр ахын төрсөн дүү ажээ. Тэрбээр өөрийгөө Хүчээ гэдэг одоо 14 настай гэж товчхон танилцуулаад хоол цайгаар дайлав. Хоол идэх зуур түүнийг жаал ажиглан суулаа, тэрбээр зүгээр сууна гэж ер үгүй, харахад л хүмүүлжилтэй, дуулгавартай, тэрбээр гэр орны ажилыг хэнээс ч дутахааргүй хийдэг нь илхэн. Цай хоолоо идэж дуусмагцаа хүү угааж арчих ажилдаа орно угаасан аягаа ахин дахин арчиж зүлгэх нь түүнийг хачин нямбай гэдгийг илтгэнэ. Үг дуу цөөтэй, нуруулаг хийгээд унаган махтай, цовоо сэргэлэн Хүчээ хэдий том биетэй болов ч хурдан шалмаг хөдөлгөөнтэй ажилд сайн, чих зөөлөн аж. Н.Мөнхбаяр гуай яриа дундаа ах дүү дөрвүүлээ гэж хэлээд эгч, дүү хоёр нь тусдаа гарсан одоо тэрбээр аав ээж болон хамгийн бага дүүтэйгээ аз жаргалтай амьдарч байгаа талаараа ярив. Энэ бүхний дараа бид нойрмоглох талдаа орж шөнө гэхэд дуг нойрондоо дугжирч өглөөний нартай золгов.

Нарны гэрэл аль хэдийн ханын толгойд тусжээ. Гэрээс гармагцаа эргэн тойрноо эргүүлэн харвал бэлчээрийн захад Хүчээгийн бараа сүүмийн сүүмийн харагдана. Хүн бүр дор бүрнээ урдах ажилдаа ханцуй шамлан орж гагцгүй хөдөө талын аниргүй байдал биднийг хөнгөн гунигт автуулжээ.

Ийнхүү миний явах цаг болж хөдөөгийн сайхан талыг орхин нийслэл рүү зорив.